



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 275

Улаанбаатар хот

"Гялс төгрөг" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 15 дугаар зүйлийн 15.3, Хорооны 2015 оны 405 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Гялс төгрөг" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Гялс төгрөг" ХЗХ /Б.Наранбат/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН